

G. J. RAMSTEDT

Einführung in die Altaische Sprachwissenschaft

FORMENLEHRE

bearbeitet und herausgegeben
von
Pentti Aalto

HELSINKI

1952

АЛТАЙ ХЭЛШИНЖЛЭЛИЙН УДИРТГАЛ

Г.И.Рамстедт

III. Тооны нэр¹

§35. А. Үндсэн тооны нэр

Бусад овгийн хэл, тухайлбал, энэтхэг-европ овгийн хэлний тооны нэрийн төрөл шинж төвөггүй танигддаг нь тухайн хэлнүүдийн хоорондын холбоо хамаарлын хөдлөшгүй баримт болдог бол алтай овогт багтдаг хэлний тооны нэрэнд нийтлэг зүйл маш бага илэрдэг төдийгүй гарлын хувьд нилээд ойр төстэй хэлэндээ ч ихэнх тохиолдолд тооны нэр хоорондоо илт ялгаатай байдаг. Жишээлбэл: ман. *уун* “ес” (уугуул утга нь “өчүүхэн, бага”), түнг. *уегин* (id); түр. хэл. *йц* “гурав” (= монг. *уцүкен*), монг. *gurban* (id) [*gurmasun*; *gunani* > түр. *qunan* (id)], түнг. *илан* “гурав” (< *ilča*- “сүлж-”).

Эдгээр хэлэнд зөвхөн “дөрөв”-ийн тоо заасан үгс гарал нэгтэй байх боломжтой. Тухайлбал: түр. *tört*, як. *tüört*, чув. *tâvat*, монг. *dörben*, түнг. *digin*, *duyin*, ман. *duin*, солонг. *turi*, х-солонг. *nduyin*, *nduin* ~ *neyin*, *ney*. Өвөг хэлнийхээ **do* гэсэн язгуураас үүссэн бололтой (SKE, 277).

1: монг. *nigen*~*niken*, халм. *nign*, даг. *nike* тооны нэр нь *neji* гэх нэр үгтэй холбогдох ёстой бөгөөд *neyile* “нийл-, нэгд-” гэх мэт үйл үг үүссэн. Түрэг хэлний *bir* “нэг” гэдэгтэй гарлын хувьд монгол хэлний *büri* тохирох бол харин манж хэлний *etun*, *etu*, түнг. *utun* “нэг” гэдэгтэй монгол хэлний **emün* “өмнө”, өгөх оршихын тийн ялгалтай *emüne*, халм. *ömnö* “өмнө зүг” хэмээхтэй гарал нэгтэй байх ёстой. Солонгос хэлний *han* “нэг” нь манж хэлний *sonio* “ганцаардмал” гэдэгтэй ойр бололтой (SKE, 60).

2: монг. *qojar* “хоёр” нь *qojina* гэдгийн *qoji*- язгуураас үүсэлтэй бололтой. Анхдагч утга нь *qojar* буюу “дараагийн, удаах” байх ёстой (лат. *sequor* гэдгээс *secundus* гэж үүссэнтэй харьцуулна уу). Түрэг хэлний *eki* “хоёр” гэх тооны нэр нь **ek*-<**hek*-<**pek* “дага-, араас ор-” хэмээх үйл үгээс үүссэн -*i*-ээр төгссөн нэр бөгөөд үүнтэй солонгос хэлний -*m*-ээр төгссөн *pegim* (<**pek-im*) “ойрын, дараагийн” гэх үг холбоотой юм. Солонгос хэлний *pegim t'e* “next place” > түр. *ekinti* “үдээс хойш” (SKE, хууд. 195). Энэхүү үндэстэй монгол хэлний *ikis* “хойдох, ихэс” хэмээх үг холбогдох мэт. Монгол хэлний *žirin* “хоёр” (*žiči*, *žirmesün*; *žitüge*-; *žitüger*> якут. *sütüör* “нэг эхийн, нэг эцгийн”; *žirmudasun* гэдэгтэй харьцуулна уу. Бүгд <**di*-?) гэдгийг түнг. *ži*, *žiur*, монгол. *žür* “хос”, монг. *žöbeger*> ордос. *Dzöwör* “хоёр юмны нэг нь”, манж. *žue*, *žiwe*, солонг. *tuwur* (<**tü-bur*, айну хэлний *tu* “хоёр” хийгээд түнгүс хэлний *du-te* “хоёрдмол болох” гэдэгтэй харьцуулна уу) (SKE, 274).

3: Түнгүс хэлний *илан* “гурав” гэдэг нь *ilča*- “сүлж-” (монгол хэлний *ilagu*, солонгос хэлний *il-gop* “долоо” < үгч. “гурав нугалсан, дарсан” гэдэгтэй харьцуулна уу) гэдгээс үүссэний нэгэн адил монгол хэлний *gurban* “гурав”, *gurmasun* “гурваар дарж сүлжсэн” (олс),

¹ Орос хэлнээс орчуулсан: Б.Даваасүрэн

gurmasula- “гурваар дарж сүлжсэн” (гээг), *gunan* “гурван настай” (малын тухайд) зэрэг нь хоорондоо холбоотой юм. Солонгос хэлний *se, set* “гурав” (*serhin* “гуч”, *sahil* “гурван өдөр” < *se-hai-la*) нь манж хэлний *sertei* “гурван үзүүрт жад”, монг. *serege, serige, serije* “гурван үзүүрт жад, сэрээ” > тел. *sārā* “жалан, гинжит сум” (SKE, 225). Түүнчлэн солонг. *tue* “few” < **tu-se* “2–3”.

5: монг. *tabun*, кидан. *tabun* “тав” гэдгийг **tā-bun*, солонгос хэлний *tā* “бүгд, бүх” хийгээд *tā-sqt* < **tā-sqsi* эсвэл *tad-* “түгж-, хаа-” гэдэгтэй харьцуулна уу. **sqs* (*jesit* “зургаа” гэдэг үгийн *-sis*)-ийн анхдагч утга нь “гар, нударга” гэсэн утгатай байсан бололтой бөгөөд *son* “гар” гэдэгтэй гарал нэг байх (SKE, 258). Эдгээр үгтэй манж хэлний *sun-ža* “тав”, түнгүс. *sō-lto* “нударга”, гольд. *sosi*, манж. *susai*, солонг. *su'i* “тавь (тоо)” зэрэг үг холбоотой. Түнгүс хэлний *tuŋŋan, tuŋgan, tunga* “тав” гэдэг нь хят. -солонг. хэлний *ton* “таван байшингаас бүрдэх бүлэг” хэмээхээс гаралтай нь эргэлзээгүй юм (SKE, 284). Түрэг хэлний *beši* “тав” гэдэгтэй чуваш хэлний *pilək ~ pillək* (адил утгатай), казах хэлний *bilek* (адил утгатай), түнг. лам. хэлний *bilän* “бугуй” + *-luq ~ -lük* холбоотой байх ёстой.

6: Түрэг хэлний *altu* “зургаа” гэдэг нь *al-* “ав-” хэмээх үйл үгээс үүссэн “авалт” гэх утгатай нэр үгтэй холбоотой байх. Монгол хэлний *žirgugan* “зургаа” нь гольд ба ольч. *ñuŋgu*, орош. *ñuŋu*, манж. *niŋgun*, негидал. *ñuŋgun* гарал нэгтэй байж магадгүй юм.

7: Солонгос хэлний *nilgor* “долоо” = түнг. *ilan* “гурав” + солонг. *kor* “нугалсан, хумьсан” буюу үгчилбэл “гурван (орч. хуруу) нугалсан” (SKE, 167) гэсэн утгатай юм. Түрэг хэлний *jeti* “долоо” гэдэг нь *je-* “ид-” буюу үгчилбэл, “иддэг хуруу” = “хоол иддэг хуруу” гэдгээс үүсжээ. Энэ нь монгол хэлний *doluga-* “долоо-” гэдгээс *dolugan* “долоо”, өөрөөр хэлбэл “долоодог хуруу” гэдгээс үүссэнтэй адил юм.

8: Монгол хэлний *najiman* “найм”. Хуруугаар тоолоход “найм”-ын тоо дунд хуруун дээр оногддог учир “найм”-ын тоог нэрлэдэг үгийн анхдагч утга нь “урт, том” гэх утгатай байх ёстой. Түнгүс хэлний *žapkun* “найм” гэдэг нь *žabdar* “урт”; *žabdan* “могой”. Солонгос хэлний *jedelp ~ jedilp* гэдгийг *jel* “арав” + **tulp* (< *tu*+) “хоёр дутуу” гэж задлаж болох юм (SKE, 76). Түүнчлэн түрэг хэлний *sekiz* гэдгийг *eki*-ээс үүсэлтэй хэмээн үзэж болмоор буюу *ekiz, ikiz* “ихэр” монгол хэлний *ikire* гэдэгтэй харьцуулна уу.

9: Түрэг хэлний *toquz* “ес” гэдгийг монгол хэлний *toqur ~ tokir* “нугардаггүй хуруу”-тай холбож үзэж болох бөгөөд үүнээ *-z* нь *sekiz* гэдгийн нэгэн адил үүссэн байж болно. Солонгос хэлний *ahop* “ес” < *a* “жигжигхэн, бага” + *kor* “нугал- тахий-” буюу “жигжиг (хуруу) нугалсан” гэсэн утгатай болно. Үүнтэй адил манж. *ujun* “ес” гэх тооны нэр түнг. *ujun* “жигжиг, бага” гэдэгтэй холбогдох ёстой (SKE, 65).

10: Эдгээр хэлэнд эртний хийгээд нийтлэг байсан хэлбэр нь түрэг хэлний *on* “арав” ~ *-an* бололтой. *seks-en* “ная (орч. найман арав)”, *toqs-an* “ер (орч. есөн арав)”. Түүнчлэн монгол хэлний *žiran* “жар”, *dalan* “дал”, *najan* “ная”, *jiren* “ер” гэдэгт орсон *-an* дагавар. Солонгос хэлний ~ *on* “зуу” (SKE, 177). Манж хэлний *žuan* “арав”, түнг. *žān* “арав” гэдэг нь манж, гольд хэлний *žuan-* “нээ-, дэлгэ-” гэдгээс үүсэлтэй. Харин солонг. *jel* “арав” гэдэг нь *jel-da* “нээ-, дэлгэ-” үүсэлтэй бөгөөд үгчилбэл, “нээсэн гар, дэлгэсэн гар” гэсэн утгатай болж байна (SKE, 77). Монгол хэлний *arban ~ harban* гэдэг тооны нэрийг *arbalža-* < **harbalža-* “далбагна-, арзай-, өрвий-” гэх үйл үгтэй харьцуулж үзвэл зохилтой.

11: Эртний түрэг хэлний *bir jigirmi* “арван нэг” гэдгээс үзэхэд зөрчид хэлэнд *gurxon* “арван гурав” гэж бүтдэг тоолох аргатай ижил байна (< монг. *gurban* + монг. *qorin*), *dur-xon* “арван дөрөв”, манж. *um-šon* “арван нэг”, манж. *tofoxon* “арван тав” (SKE, 259).

20: Түрэг хэлний *jigirmi* “хорь” нь МНТ-ны *jirin* “хоёр, хос” гэдэгтэй адил бөгөөд үүнээс одоо хир хэрэглэгдэж буй *žirmesün* “жирэмсэн” гэдэг үг үүссэн болно (халх. *dabxur* (мөн утгаар) гэдэгтэй харьцуулна уу). Түүнчлэн *gurmusun* “гурваар дарж сүлжсэн”, *dörmüsün*

“дөрвөөр дарж сүлжсэн”. Тиймээс *žigirme* гэдэг нь **žigür-* ~ *žigir-* “хоёр болго-, хос болго-” гэх үйл үгээс үүссэн нэр үг байх ёстой. Түүнчлэн якут. *sūrbā* “хорь” хэмээх тооны нэр **žigürme* ~ **žigürmi* гэдгээс үүсэн. МНТ-ны *ži'ürme-de-* “хоёр болго-, хос болго-” нь түрэг хэлний *jigürme* адил утгатай болно.

30: Түрэг хэлний *otuz* ~ *ottuz* ~ *oltuz* “гуч” солонг. *potari*, *pottari* “зангилаа, зангидаас” гэдэгтэй холбож үзэж болох юм. Солонгос хэлний *tirīm*, *turīm* “хорин ширхэг” < “20 ширхэгээр багцлаж боосон загас”; түр. *tizim* “сувд хэлхэх утас” (SKE, 277).

Түрэг хэлний *on* “арав” солонг. *on* хоорондоо тохирох боловч солонгос хэлэнд *on* гэдэг нь “зуу”-ийн тоог заадаг. Үүнтэй адил түнг. *žān*, сол. *d'žan*, манж. *žuwan* “арав” гэдгийг монг. *žagun* “зуу”-тай адилтгаж болно. Түнгүс хэлний *namaži*, *namad'i* “зуу”-ийн тоо заадаг боловч “шуудай, шуудай дүүрэн” гэх утга бас илтгэнэ. Өөрөөр хэлбэл, хэмжээс буюу (< *nama-* “ач-, цаа буганд ачаа ач-”) эрт. солонг. *namat* “шуудай, халаас” гэдэгтэй холбогддог нь эргэлзээгүй. Үүнтэй нэгэн адил түр. *jüz* “зуу”-ийн тооны нэр *jü-* “ач-, ачаа ач-” гэдэг үйл үгээс үүссэн байх ёстой (монг. *žüe-*, *žüge-* “id”) (*tara-z*, *qumy-z* гэх мэт үг үүссэн аргатай харьцуулна уу. SKE, 43).

Эртний түрэг хэлний *byñ*, уйг. *myñ*, чув. *piñ*, монг., түнг. *mingan* “мянга”, түр., монг., түнг. *tümān* “арван мянга” ба солонг. *čimjñ* “мянга” гэх тооны нэр хоорондоо дэндүү адил байгааг өвөг хэлний нийтлэг шинжээ хадгалж үлдсэн гэж үзэх боломжгүй юм. Эдгээр тооны нэр хожуу үеийн үр дүн бөгөөд зарим тохиолдолд ормол гэж үзэж болно (жишээлбэл, тохар хэлний *tumane* “арван мянга” гэдгийг харьцуулна уу).

Б. Дэс тооны нэр

Эдгээр хэлэнд дэс тоо заадаг эртний нийтлэг шинж маш бага илэрдэг. Монгол хэлэнд дэс тооны үүргээр үндсэн тоог өөрчлөлгүйгээр хэрэглэдэг (*gurban sara* “гурван сар, гурав дугаар сар”). Гэхдээ дэс тоо заадаг сул үг хэрэглэх нь бас бий. Жишээлбэл. *gurbadaki* “гурван дахь, гурав дугаар” эсвэл бүр халм., бур. *gurbadakiči*. Түрэг хэлэнд дэс тоо заахдаа *-nč*, якут. *-s*, чув. *-mäs* залгавар тус тус хэрэглэдэг нь нэр үг үүсгэдэг *-či* залгавараас үүссэн бололтой. Түнгүс хэлэнд янз бүрийн аргаар үүсгэдэг боловч харьцангуй бүтээлч арга нь *-i* залгавар юм. Жишээлбэл: *ilan* “гурав”, *ili* “гурав дугаар”; үг хувилахын тухайд гэвэл *žudu* “гэрт” > *žudi* “гэрт байгаа, гэртэх...” гэдэгтэй харьцуулна уу.

Дэс тоо бүтээх адил арга манж хэлэнд байна. Жишээлбэл, *uži* “үзүүр, орой хэсэг, эхлэл хэсэг”, *užui* “нэг дүгээр”; түнг. *žal* “бусад”; манж. *žai* “хоёр дугаар, өөр бусад”. Үүнээс гадна солонгос хэлэнд бусад аялгууны нэгэн адил *тэр жил*, *тийм жил* гэх утгатай **-či* залгаж үүсгэдэг (түрэг хэлний *-nč* залгаварын *-č*-тэй харьцуулна уу). Жишээлбэл: *žūtči* “хоёр дах жил”, *ilasi* “гурав дах жил” (= манж. *ilači* “гурав дах, гурав дугаар” < үгч. “гуравтай...”), *dujusi* “дөрөв дэх жилдээ” (манж. *du-juči* “дөрөв дэх, гурав дүгээр”). Монгол хэлний *žirmusun* (< *žirin* “хоёр”) “жирэмсэн” < үгч. “давхар”, *gurmusun* “гурваар дарж сүлжсэн” гэсэн утгатай атал манж. *ilča-* (< *ilan* “гурав”) “(үс) сүлж-”.

Б. Хам тооны нэр

Түрэг монгол хэлний аль алинд хам тооны нэр *-agi*, *-ai* залгавараар бүтдэг. Жишээлбэл, түр. *üçai* “гурвуулаа”, *törtai* “дөрвүүлээ”, *altai* “зургуулаа”; монг. *gurbagula*, *dörbegüle*, *žirgagula*; чув. *vunnā* “арвуулаа”, түр. *onai* “арвуулаа”, якут. (*uon* >) *onuо* харьцуулна уу. Магадгүй энэ *-agi*, *-ai* нь үгийн гарлын хувьд монг. *agulža-*, калм. *ülz-*, солонг. *aorj-* “цуглуул-”, *aolla* “цуг, хамт” гэх мэт үйл үгтэй ойр байх. Монгол хэлний *qoyagula*, *gurbagula*, *dörbegüle* гэх мэтэд орсон *-la*, *-le* нь хам эсвэл хүч оруулсан утгатай бөгөөд монг. *qotola* “бүгд”, үгч. “хот даяараа” (< *qoto* “хот, хүрээ”); орчин цагийн монгол хэлний *ханала* “бүгд” < үгч. “нийт даяараа” (< **kwan-a* = солонг. *kwan-ja* “Хвана муж”); о. ц. м. хэл. *χūla* “бүгд” (< о. ц. м. хэл. *χū*, алт. *qor* “бүгд”, гольд. *hopan* “бүгд”). Мөн ийм залгаавар монгол хэлэнд *jekele* “ихэнх хэсэг”. Түүнчлэн түр. *birlä* “... -тай хамт, ... -тай цуг”, *künlä tünlä* “өдөр шөнө” гэх мэт.

Монгол хэлний *nigente*, *qoyarta*, якут. *birtä*, *ikkitä* гэх мэтийг §126 үзнэ үү.